SBG SWISSBETTERGOLD

Мэдэгдэл хийх удирдамж

2025 оны 8-р сар



SWISS BETTER GOLD МЭДЭГДЭЛ ХИЙХ УДИРДАМЖ[1]

Агуулга

1. Танилцуулга: SBG Холбооны санаачилга 3
2. SBG: Харагдах дүр төрх, мэдээлэл харилцаа, барааны тэмдгийн бүртгэл.....3
3. Барааны тэмдэг ашиглах 4
4. SBG-ийн мэдэгдлийг хэн хийж болох вэ? 5
5. Гишүүдийн мэдэгдэл 5
6. Хамтрагч уурхайн мэдэгдэл 6
7. Хэрэгжүүлэгч түншүүдийн мэдэгдэл 7
8. Байгууллагын түншүүдийн мэдэгдэл..... 8
9. Олон улсын худалдаачдын мэдэгдэл 9
10. Баяжуулах үйлдвэрүүд / дундын цэвэршүүлэгчдийн мэдэгдэл.. 10
11. Нийлүүлэгч гишүүдийн гарал үүслийн мэдэгдэл..... 10
12. Мэдэгдлийг хянах 11
13. Мэдэгдлийг зохисгүй ашиглах 12

[1] Swiss Better Gold-ийн Мэдэгдэл хийх удирдамж нь Нийгэм, байгаль орчны магадлан итгэмжлэл ба шошгожуулалтын олон улсын холбооны (ISEAL) Сайн туршлагын кодекст нийцсэн болно.

1. Танилцуулга: Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association) Санаачилга

Швейцарын Хариуцлагатай алтны холбоо (Swiss Better Gold Association-SBG) нь ашгийн бус салбарын холбоо бөгөөд гишүүд нь алтны салбарын гол тоглогчдыг төлөөлдөг. Тус холбооны зорилго нь бичил уурхайн алт олборлолт, мөн шаардлага хангасан тохиолдолд дунд оврын уурхайн үйл ажиллагааг дэмжиж, эдгээр үйлдвэрлэгчдээс гишүүд хүртэлх хариуцлагатай алтны нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхэд оршино.

2013 онд Холбоо нь Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн Нарийн бичгийн дарга нарын газар (SECO)-тай хамтран төр-хувийн хэвшлийн түншлэлд орж, энэ хүрээнд SBG Санаачилгыг эхлүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь уул уурхайн үйлдвэрлэгчдэд техникийн туслалцаа үзүүлэх, нийгэм болон байгаль орчны үйл ажиллагааг сайжруулах замаар тэднийг SBG-ийн нийлүүлэгчээр магадлан итгэмжлэгдэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү удирдамжийн хүрээнд "мэдэгдэл" гэдэгт SBG-ийн оролцогч талуудын SBG-тэй хамтран ажиллаж буй оролцоо, SBG-тэй байгуулсан хамтын ажиллагааны үр дүнд бий болсон үр нөлөө, SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хангаж буй байдал, эсвэл SBG-тэй холбоотой бусад аливаа харилцааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах зорилгоор хийсэн мэдээлэл харилцааны (мэдэгдэл) бүхий л хэлбэрүүд багтана. Мэдэгдлийг нийгмийн сүлжээ, оролцогч талуудын мэдээлэл, харилцааны шугам, (жишээ нь, тогтвортой хөгжлийн тайлангууд), эсвэл талуудын ашигладаг мэдээллийн бусад хэлбэр, загвар зэрэг мэдээллийн сувгуудаар түгээж болно.

2. Swiss Better Gold: Харагдах дүр төрх, мэдээлэл харилцаа, барааны тэмдгийн бүртгэл

SBG Холбоо нь “SBG Swiss Better Gold” барааны тэмдгийг бүртгүүлсэн болно.

SBG SWISSBETTERGOLD

SBG Swiss Better Gold барааны тэмдэг нь уурхайгаас зах зээл хүртэлх хариуцлагатай алтны нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход оролцож буй олон талууд болон тэдний хэрэгжүүлж буй санаачилгуудыг нэгтгэсэн нийтлэг таних тэмдэг юм. Энэ нь мэдээлэл, харилцаа холбоог ойлгомжтой, үр дүнтэйгээр хүргэх боломжийг бүрдүүлдэг.

Swiss Better Gold гэсэн нэршлийг дангаар нь эсвэл “Холбоо”, “Санаачилга”, “Хөтөлбөр”, “Шаталсан хөгжлийн аргачлал”, “Эх үүсвэрийн стратеги” зэрэг бусад нэр томьёотой хамтатган хэрэглэнэ. Тухайлбал, Swiss Better Gold Холбоо; Swiss Better Gold Санаачилга; Swiss Better Gold Шаталсан хөгжлийн аргачлал; Swiss Better Gold Эх үүсвэрийн стратеги; Swiss Better Gold Сан г.м

Swiss Better Gold-ийн товчлолыг "SBG" гэж ашиглаж болно. Жишээ нь: SBG Холбоо, SBG Санаачилга, мөн SBG Шаталсан хөгжлийн аргачлал, SBG эх үүсвэрийн стратеги г.м.

Гэсэн хэдий ч баримт бичигт товчлолыг анх удаа хэрэглэхдээ бүтэн нэрийг эхлээд заавал бичиж тодорхой болгоно. Жишээ нь: Swiss Better Gold (SBG).

3. Барааны тэмдэг ашиглах

Бүртгэлтэй барааны тэмдэг нь үсэг, болон дүрслэл тэмдгээс бүрдэнэ.

SBG SWISSBETTERGOLD

Энэхүү барааны тэмдэг нь Swiss Better Gold Холбоо болон Swiss Better Gold Санаачилгын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг илэрхийлэх бөгөөд үндсэн таних тэмдэг болж ашиглагдана.

Түүнчлэн, Swiss Better Gold системийн оролцогч тал тус бүрийг тодруулан, ялган таних зорилгоор тухайн тохиолдол бүрд дараах нэмэлт хувилбаруудыг харгалзан үзэж болно.

Холбооны хувьд харагдах дүр төрх болон нэршил:

SBG SWISSBETTERGOLD
ASSOCIATION

Санаачилгын хувьд англи хэлээр харилцах таних тэмдэг болон нэршил:

SBG SWISSBETTERGOLD
INITIATIVE

Санаачилгын хувьд испани хэлээр харилцах таних тэмдэг болон нэршил:

SBG SWISSBETTERGOLD
INICIATIVA SUIZA ORO RESPONSABLE

4. Swiss Better Gold мэдэгдлийг хэн хийж болох вэ?

Swiss Better Gold мэдэгдлийг дараах байгууллага хийж болно. Үүнд:

- Swiss Better Gold Холбооны гишүүд;
- Swiss Better Gold нийлүүлэгчид;
- Swiss Better Gold хэрэгжүүлэгч түншүүд;
- Swiss Better Gold байгууллагын түншүүд;
- Swiss Better Gold той хамтрагч олон улсын худалдаачид;
- Swiss Better Gold-той хамтрагч Баяжуулах үйлдвэрүүд (дундын цэвэршүүлэх үйлдвэрүүд).

SBG Холбоо нь гишүүдээсээ гарал үүслийн мөн бүтээгдэхүүний мэдэгдэл (бүтээгдэхүүн дээр эсвэл сурталчилгаанд) хийхийг шаарддаггүй. Дэлгэрэнгүй мэдээллийг 10 дугаар хуудаснаас үзнэ үү.

Бүх оролцогч тал энэхүү Мэдэгдэл хийх удирдамжийг чанд мөрдөх бөгөөд энэхүү гарын авлагад дурдсан жишээнээс өөр агуулгатай аливаа мэдэгдэл хийхийн өмнө SBG Холбооны Нарийн бичгийн дарга нарын газраас бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай (info@sbga.ch).

5. Гишүүдийн мэдэгдэл

SBG Холбооны гишүүд доорх хүснэгтэд нийцсэн мэдэгдлийг хийж болно.

Таны гишүүнчлэл (доорх логотой хамт хэрэглэнэ) SBG SWISSBETTERGOLD ASSOCIATION	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold Холбооны гишүүн.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold Холбоонд XXXX оны XX сард гишүүнээр элссэн.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold Холбооны Удирдах зөвлөлд төлөөлөлтэй.
Таны үүрэг амлалт (доорх логотой хамт хэрэглэнэ) SBG SWISSBETTERGOLD SBG SWISSBETTERGOLD ASSOCIATION	Бид (эсвэл байгууллагын нэр) гишүүнээр элсэж, эх үүсвэрийн шалгуурыг мөрдсөнөөрөө Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн Нарийн бичгийн дарга нарын газар (SECO) болон Swiss Better Gold Холбооноос хэрэгжүүлж буй Swiss Better Gold Санаачилгыг дэмжиж, бичил уурхайн салбар дахь нийгэм, байгаль орчны нөхцөлийг сайжруулахад чиглэсэн нийтлэг зорилгод нэгдэж байна.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold болон хариуцлагатай үул уурхайн үйлдвэрлэгчдийг дэмжих үүрэг амлалттай.

	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold болон бичил уурхайн үйлдвэрлэгчдийн орон нутагт чиглэсэн тогтвортой хөгжлийг дэмждэг.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-д оролцсоноороо бичил уурхайн салбарт нийгэм, байгаль орчны арга туршлагыг сайжруулах үүрэг амлалттай.
	Бид бичил уурхайн үйлдвэрлэгчдийн нийгэм, байгаль орчны арга туршлагыг илүү сайжруулахад хувь нэмэр оруулж буй Swiss Better Gold-ийн үйл ажиллагааг дэмжин сайшаадаг.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-ийн дэмжин ажилладаг үйлдвэрлэгчдийн олборлосон алтыг эх үүсвэрээ болгодог.
	XXXX оны XX сараас XXXX оны XX сар хүртэл, бид (эсвэл байгууллага) XX кг алтыг эх үүсвэр болгон Swiss Better Gold-д хувь нэмэр оруулснаар XX ам.долларын нөлөөллийн урамшуулал* бий болгосон.

* 10-р хуудас дахь Гарал үүслийн мэдэгдлийн хэсгийг үзнэ үү.

6. Хамтрагч уурхайн мэдэгдэл

Хоёрдугаар шатанд магадлан итгэмжлэгдсэн бөгөөд улмаар SBG-ийн эх үүсвэрийн бүх шалгуурыг хангаж буй SBG-ийн нийлүүлэгчид доорх жишээнүүдэд нийцсэн мэдэгдэл хийж болно.

SBG-ийн баримт бичгийг уурхайн ажилтнуудын хүрээнд түгээхийг зөвшөөрнө. Харин нууцлалын тодорхой шалтгааны улмаас “SBG магадлан итгэмжлэлийн гэрчилгээ”, гэрээнүүд, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн захидлууд, SBG-ийн ажлын баримт бичиг (Тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөө) зэрэг SBG-ийн баримт бичгүүд болон тэдгээртэй адилтгах бусад материалыг олон нийтийн сувгаар, ялангуяа интернэтэд түгээх, нийтлэхийг хатуу хориглоно.

Таны нийлүүлэгч статус (доорх логотой хамт ашиглана) SBG SWISSBETTERGOLD	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) Swiss Better Gold-н хөтөлбөрт оролцдог.
	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) XXXX оны XX сард Swiss Better Gold-ийн нийлүүлэгч болсон.
	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) Swiss Better Gold-ийн бүрэн магадлан итгэмжлэгдсэн нийлүүлэгч байгуулага юм.
	Бидний олборлосон алт Swiss Better Gold-ийн шалгууруудыг хангадаг.
	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) Swiss Better Gold-ийн эх үүсвэрийн стратегид тодорхойлсон байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны шаардлагыг хангаж байгааг хараат бус байдлаар баталгаажуулсан.

Таны үүрэг амлалт (доорх логотой хамт ашиглана) SBG SWISSBETTERGOLD INITIATIVE SBG SWISSBETTERGOLD INICIATIVA SUIZA ORO RESPONSABLE SBG SWISSBETTERGOLD	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) Swiss Better Gold-н хөтөлбөрт оролцсоноороо үул үурхайн ажиллагаагаа сайжруулах үүрэг амлалттай.
	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) Swiss Better Gold-н хөтөлбөрт оролцож нөлөөллийн урамшууллыг ашигласнаараа олон нийтэд чиглэсэн тогтвортой хөгжлийг дэмждэг.
	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) Swiss Better Gold-ийн нийлүүлэгч.
	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) XXXX оны XX сараас XXXX оны XX сар хүртэл Swiss Better Gold-д XX кг алт нийлүүлсэн.

SBG-ийн түнш уурхайнууд, түүнчлэн 1-р шат дахь үйлдвэрлэгчид хөтөлбөрт оролцож байгаа болон хариуцлагатай уул уурхайн практикийг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан тухай ерөнхий мэдэгдлийг доорх хүснэгтэд дурдсан жишээний дагуу хийж болно.

Таны нийлүүлэгч статус (доорх логотой хамт ашиглана) SBG SWISSBETTERGOLD	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-д оролцдог.
Таны үүрэг амлалт (доорх логотой хамт хэрэглэнэ) SBG SWISSBETTERGOLD INITIATIVE SBG SWISSBETTERGOLD INICIATIVA SUIZA ORO RESPONSABLE	Бид (эсвэл үйлдвэрлэгчийн нэр) Swiss Better Gold-н хөтөлбөрт оролцсоноороо үул уурхайн үйл ажиллагаагаа сайжруулах, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангах үүрэг амлалттай.

7. Хэрэгжүүлэгч түншүүдийн мэдэгдэл

SBG Холбооны хамтрагч байгууллагууд доорх хүснэгтэд нийцсэн мэдэгдлийг хийж болно.

Swiss Better Gold-той холбоотой таны хамтын ажиллагаа ба хувь нэмэр (доорх логотой хамт хэрэглэнэ)	Бид (эсвэл байгууллага) Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн Нарийн бичгийн дарга нарын газартай (SECO) хариуцлагатай бичил уурхайг дэмжих зорилгоор хамтран ажилладаг анхдагч хөтөлбөр болох Swiss Better Gold санаачилгыг хэрэгжүүлдэг.
	Бид (эсвэл байгууллага) XXXX оны XX сараас Swiss Better Gold-ийн хэрэгжүүлэгч түншээр ажиллаж байна.

SBG SWISSBETTERGOLD INITIATIVE SBG SWISSBETTERGOLD INICIATIVA SUIZA ORO RESPONSABLE SBG SWISSBETTERGOLD	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-той хамтран ажилласнаараа уул уурхайн нийгэм, байгаль орчны арга туршлагыг сайжруулахад хувь нэмрээ оруулна.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-ийн хэрэгжүүлэгч түншийн хувьд, хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаараа хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээ бий болгохыг дэмждэг.
	Swiss Better Gold нь бичил уурхайн үйлдвэрлэгчдийг шууд дэмжиж ажилладаг бөгөөд тэднийг Swiss Better Gold-ийн эх үүсвэрийн шалгуур хангахад нь дэмжлэг үзүүлдэг.
	Swiss Better Gold бичил уурхайн үйлдвэрлэгчдийг шууд дэмжиж ажилладаг бөгөөд тэднийг Swiss Better Gold-ийн Тасралтгүй сайжруулалтын шатлалаар өгсөхөд нь дэмжлэг үзүүлдэг.
	Бичил уурхайг сайжруулах явцыг дэмжсэнээр Swiss Better Gold нь бичил уурхайн салбарын нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр зорьж байна.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-ийн уул уурхайн үйлдвэрлэлийн нийгэм, байгаль орчны арга туршлагыг сайжруулахыг дэмждэг.
	Swiss Better Gold бичил уурхайчдад тусгайлан зориулсан (сургалтын нэр) сургалтад урьж байна.

8. Байгууллагын түншүүдийн мэдэгдэл

Одоогийн байдлаар SBG Холбооны SBG Санаачилгын үндсэн хамтрагч нь Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн Нарийн бичгийн дарга нарын газар (SECO) юм. Тиймээс SECO-ийн үүрэг оролцоотой нийцэх гол мэдэгдлүүд доорх хүснэгтэд үзүүлсэн жишээтэй адил байна.

Таны түншийн статус ба Swiss Better Gold-ийн дэмжлэг (доорх логотой хамт ашиглана) SBG SWISSBETTERGOLD INITIATIVE SBG SWISSBETTERGOLD INICIATIVA SUIZA ORO RESPONSABLE	Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга нарын газар (SECO) болон Swiss Better Gold Холбоо нь бичил уурхайн салбар дахь ядуурлыг бууруулах, нийгэм, байгаль орчны нөхцөлийг сайжруулах зорилгоор хүчээ нэгтгэн Swiss Better Gold Санаачилга хэмээх төр-хувийн хэвшлийн анхдагч түншлэлийг байгуулсан.
	2013 оноос хойш, Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга нарын газар (SECO) нь Swiss Better Gold Холбооны төрийн түншлэгч болсон.
	SBG Санаачилга нь SBG Холбоо болон Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн Нарийн бичгийн дарга нарын газрын (SECO) хооронд байгуулсан төр-хувийн хэвшлийн

	өвөрмөц түншлэл бөгөөд бичил уурхайн үйлдвэрлэгчдийг нийгэм, байгаль орчны илүү сайн арга туршлагыг хэрэгжүүлэх үйлсэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.
	Swiss Better Gold Санаачилгыг бий болгосноор Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн Нарийн бичгийн дарга нарын газар (SECO) болон Swiss Better Gold Холбоо нь бичил уурхайн салбар дахь ядуурлыг бууруулах, нийгэм, байгаль орчны нөхцөлийг сайжруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулдаг.
	Swiss Better Gold Санаачилга хэмээх төр-хувийн хэвшлийн түншлэлээрээ дамжуулан Swiss Better Gold Холбоо болон SECO нь бичил уурхайн үйлдвэрлэгчдийг техник, зохион байгуулалт, нийгэм, байгаль орчны арга туршлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, хариуцлагатайгаар үйлдвэрлэсэн бичил уурхайн алтыг сурталчлан таниулж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэн, бичил уурхайтай холбоотой сорилтуудын талаар иргэний нийгэмтэй нээлттэй яриа хэлэлцээ хийхэд нь дэмжлэг үзүүлдэг.

9. Олон улсын худалдаачдын мэдэгдэл

Шаардлагатай тохиолдолд SBG нь нийлүүлэлтийн сүлжээг хөнгөвчлөхийн тулд олон улсын худалдаачидтай хамтран ажилладаг. Олон улсын худалдаачид нь алтны нийлүүлэлтийн сүлжээний чухал бүрэлдэхүүн хэсэг учраас SBG-ийн чухал түнш юм. Худалдааны түншүүд доорх хүснэгт дэх жишээтэй нийцсэн мэдэгдэл хийж болно.

Swiss Better Gold -той таны хамтын ажиллагаа (доорх логотой хамт ашиглана) SBG SWISSBETTERGOLD SBG SWISSBETTERGOLD INITIATIVE SBG SWISSBETTERGOLD INICIATIVA SUIZA ORO RESPONSABLE	Бид (эсвэл байгууллага) хариуцлагатайгаар үйлдвэрлэсэн, гарал үүслийг нь мөшгөх боломжтой алтыг дэмжих үүрэг амлалттай учраас Swiss Better Gold нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэх болсон.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold -ийн нийлүүлэлтийн сүлжээний нэг хэсэг бөгөөд хариуцлагатайгаар үйлдвэрлэсэн, гарал үүслийг мөшгөх боломжтой алтыг экспортлохыг дэмждэг.
	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-д оролцсоноороо бичил уурхайн салбарт нийгэм, байгаль орчны арга туршлагыг сайжруулах үүрэг амлалттай.
	Swiss Better Gold хөтөлбөрт оролцсоноороо бид бичил уурхайн салбарыг дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд илүү хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг.

	Swiss Better Gold хөтөлбөрийн нэг хэсэг болсны хувьд бид бичил уурхайн салбарыг дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд илүү оролцуулахын төлөө ажилладаг.

10. Баяжуулах үйлдвэрүүд / дундын цэвэршүүлэгчдийн мэдэгдэл

Зарим нөхцөлд SBG нь бичил уурхайн үйлдвэрлэгчид болон худалдан авагчдын хоорондох нийлүүлэлтийн сүлжээг хөнгөвчлөх зорилгоор баяжуулах үйлдвэрүүдтэй (дундын цэвэршүүлэгчид) хамтран ажилладаг. Ийм тохиолдолд баяжуулах үйлдвэрүүд нь бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний чухал бүрэлдэхүүн хэсэг учир SBG-ийн чухал түнш болдог. Түнш үйлдвэрүүд доорх хүснэгт дэх жишээтэй нийцсэн мэдэгдэл хийж болно.

Swiss Better Gold -той таны хамтын ажиллагаа (доорх логотой хамт ашиглана)	Бид (эсвэл байгууллага) хариуцлагатайгаар үйлдвэрлэсэн, гарал үүслийг нь мөшгөх боломжтой алтыг дэмжих үүрэг амлалттай учраас Swiss Better Gold нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэхээр шийдсэн.
SBG SWISSBETTERGOLD	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-ийн нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн бөгөөд бичил уурхайд хариуцлагатайгаар үйлдвэрлэсэн алтны экспортыг дэмждэг.
SBG SWISSBETTERGOLD INITIATIVE	
SBG SWISSBETTERGOLD INICIATIVA SUIZA ORO RESPONSABLE	Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-д оролцсоноороо бичил уурхайн үйлдвэрлэгчдийг олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд илүү хүртээмжтэй оролцуулах, бичил уурхайн салбарт нийгэм, байгаль орчны арга туршлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

11. Нийлүүлэгч гишүүдийн гарал үүслийн мэдэгдэл

Холбооны ханган нийлүүлэгч гишүүд компанийн гарал үүслийн талаарх мэдэгдэл нь зохицуулагчид, хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчид болон иргэний нийгмийн байгууллагуудын хяналтад орох магадлалтай гэдгийг мэдэж байх ёстой.

SBG Холбоо гишүүддээ SBG хөтөлбөрт хамрагдаж буй алтны эх үүсвэрийнхээ талаар гарал үүслийн мэдэгдэл хийхийг зөвшөөрдөг. Эргэлзээ төрүүлэхээс сэргийлж, гарал үүслийн мэдэгдлийг сайн дурын үндсэн дээр хийдэг болохыг анхаарна уу.

Компанийн гарал үүслийн мэдэгдэлд SBG-д хөтөлбөрт оролцогч үүл уурхайн үйлдвэрлэгчээс шууд нийлүүлэгдэж, цэвэршүүлэх үйлдвэрээр дамжиж тусгаарласан нийлүүлэлтийн урсгалаар боловсруулагдсан алтны талаарх мэдэгдэл байж болно.

Мөн хэд хэдэн үйлдвэрлэгчийн, үүнд SBG хөтөлбөрт хамрагдаагүй үйлдвэрлэгчдийн алтыг ч багтаасан холимог эх үүсвэрийг массын балансын аргаар тооцсон алтны талаарх мэдэгдэл байж болно.

Аль ч тохиолдолд эдгээр мэдэгдэл нь алтны тоо хэмжээ (килограмм, грамм эсвэл тухайн багцын нийт хэмжээний хувь), гарал үүсэл, хяналт, бүртгэлийн тогтолцооны баталгаажуулалтын түвшнийг үнэн зөв тусгасан байх ёстой. Мэдэгдэл нь бодит баримтад үндэслэсэн байх бөгөөд гишүүдийн хүлээсэн үүрэг амлалт, тэдний эзэмшилд байгаа SBG алтны гарал үүсэл, хэмжээг төөрөгдөл төрүүлэхгүйгээр тодорхой, үнэн зөв илэрхийлсэн байна.

> Жишээ. Бид (эсвэл байгууллага) Swiss Better Gold-ийн Колумби Улс дахь XX магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчээс эх үүсвэртэй алт авдаг.
> Жишээ. Бид (эсвэл байгууллага) алтныхаа X хувийг Swiss Better Gold-ийн магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчээс авдаг.

Гишүүд компанийн гарал үүслийн ийм мэдэгдэл гаргахаар бол тухайн мэдэгдэл нь баримт бичигт тулгуурласан удирдлагын тогтолцоо, SBG-ийн түнш цэвэршүүлэх үйлдвэрүүдээс олгосон баталгаа (тусгаарлагдсан үйлдвэрлэлийн урсгал, шилжүүлгийн баримт, гэрээ хэлэлцээр г.м) зэрэгт үндэслэсэн болохыг нотлон баримтжуулж, хадгалах шаардлагатай.

SBG Холбоо нь өөр хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтын тогтолцоогоор баталгаажсан гарал үүслийн мэдэгдлийг мөн хүлээн зөвшөөрч болно. Тухайлбал, SBG Холбооны гишүүн нь Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөлийн (RJC) гишүүн байж болох бөгөөд сайн дурын үндсэн дээр гаргасан гарал үүслийн мэдэгдлээ RJC-ийн аудитын хамрах хүрээнд аудит хийлгэж, баталгаажуулсан байж болно. Уг хүрээнд Гарал үүслийн мэдэгдэл болон Хяналт бүртгэлийн тогтолцооны талаарх (Chain of Custody-CoC) Үйл ажиллагааны 14-р дүрэм (Code of Practice-CoP 14) багтана. Энэ тохиолдолд SBG Холбоо нь тухайн гишүүний RJC-ийн CoC гэрчилгээг мэдэгдлийн хүчин төгөлдөр байдлыг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрнө. Аль ч тохиолдолд эдгээр мэдэгдлийг SBG Холбооны Нарийн бичгийн дарга нарын газраар батлуулах шаардлагатай (info@sbga.ch).

12. Мэдэгдлийг хянах

SBG Холбооны Нарийн бичгийн дарга нарын газар нь SBG системийн доторх болон гаднах оролцогч талуудын гаргасан мэдэгдлийг хянах үүрэгтэй.

Нарийн бичгийн дарга нарын газар нь Холбооны гишүүд, Swiss Better Gold-ийн ханган нийлүүлэгчид, хэрэгжүүлэгч болон бусад хөтөлбөрийн түншүүдээс гаргасан мэдэгдэлд тогтмол хяналт тавьдаг. Үүнд тэдгээрийн цахим хуудас, нийгмийн сүлжээний сувгууд болон олон нийтэд нээлттэй бусад эх сурвалж, мэдээллийн сувгийг хянан шалгах ажиллагаа багтана.

Мэдэгдлийг зохисгүй ашигласан тохиолдлыг SBG-ийн баг (SBG Холбооны Нарийн бичгийн дарга нарын газар, орон нутаг дахь SBG-ийн хэрэгжүүлэгч түнш), SBG Холбооны гишүүн, эсхүл бусад аливаа хувь хүн, байгууллага илрүүлж болно.

Зөрчлийг Нарийн бичгийн дарга нарын газар илрүүлээгүй бол, Нарийн бичгийн дарга нарын газарт шууд мэдэгдэж болох бөгөөд гомдлыг цахим шуудангаар эсвэл SBG-ийн гомдол мэдүүлэх маягт (https://swissbettergold.ch/about-us) бөглөн хүргүүлж болно.

13. Мэдэгдлийг зохисгүй ашиглах

SBG-ийн мэдэгдэл хийх удирдамжийг зөрчсөн аливаа тохиолдлыг SBG-ийн мэдэгдлийг зохисгүй ашигласан гэж үзнэ. Зохисгүй ашиглалтыг *хөнгөн* болон *ноцтой* гэж ангилна.

Хөнгөн зөрчилд дараах тохиолдлууд хамаарна.

- Мэдэгдэл хийх тухай удирдамжид заасан жишгээс бага зэрэг зөрсөн бөгөөд Нарийн бичгийн дарга нарын газартай зөвлөлдөөгүй мэдэгдэл.
- Хэтрүүлсэн мэдэгдэл
- “Шилдэг туршлагууд” гэсэн батламж агуулсан, эсхүл “тогтвортой”, “тогтвортой байдал” гэсэн нэр томьёог үндэслэлгүй ашигласан мэдэгдэл.
  “Шилдэг туршлага”, “тогтвортой”, “тогтвортой байдал” зэрэг нэр томьёог ямагт нэмэлт тодотголтой хэрэглэнэ. Жишээлбэл: “илүү сайн туршлагыг дэмжих тасралтгүй сайжруулалт”, “байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулахыг эрмэлзэх”,“тогтвортой байдалд хүрэх явцдаа” гэх мэт.
- Хяналт болон/эсхүл баталгаажуулалтад тэнцээгүй үйлдвэрлэгчийг SBG -ийн нийлүүлэгч статустай хэмээн мэдэгдсэн мэдэгдэл.
- SBG Холбооны гишүүний статус (нийлүүлэгч эсвэл дэмжигч гишүүн)-ын талаар худал мэдэгдэл.
- “SBG Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ”, гэрээ, Хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн захидлууд, SBG-ийн ажлын баримт бичиг (Тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөө) болон тэдгээртэй адилтгах бусад баримт бичгийг олон нийтийн сувгаар нийтлэх, түгээх.

Ноцтой зөрчилд дараах тохиолдлууд хамаарна.

- SBG-ийн нийлүүлэлтийн сүлжээний талаар төөрөгдүүлсэн эсвэл хуурамч мэдэгдэл гаргах, жишээ нь гарал үүслийн талаарх худал мэдэгдэл.
- SBG-ийн нэр хүндэд ноцтой нөлөөлөх мэдэгдэл.

Зохисгүй ашиглалтын аль ч тохиолдолд тухайн мэдэгдэл гаргасан этгээдэд мэдэгдэж, мэдэгдлээ засварлах эсвэл устгахыг шаардана. Харин ноцтой зөрчил гаргасан тохиолдолд тухайн этгээдээс олон нийтэд залруулга хийхийг шаардаж болно.

Олон удаа санууулсаар байтал худал мэдэгдлийг хэвээр үлдээх, эсвэл давтан гаргах нь магадлал багатай ч хэрэв ийм тохиолдол гарвал SBG Холбооны Удирдах зөвлөл оролцох ба гишүүнчлэлээс хасах, эсвэл SBG хөтөлбөрт оролцох эрхийг цуцлах, худал мэдэгдлийн талаар олон нийтэд няцаалт хийх, цаашид хамтын ажиллагааг үргэлжлүүлэхийг хориглох, эсхүл хуулийн арга хэмжээ авах зэрэг залруулах арга хэмжээ авна.